

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-16
	<p>1.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол нарын 10 гишүүн 2019.10.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</p> <p>2.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2019.06.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</p> <p>3.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.</p> <p>4.Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хуулийн төслийг намрын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцүүлэгт бэлтгэх цагалбар</p>	

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 10 дугаар сарын 23-ны
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж 52,6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 24 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Амарзаяа, Ж.Батзандан, Б.Жавхлан, Б.Пүрэвдорж, О.Содбилэг, Д.Сумъяабазар, Н.Цэрэнбат;

Тасалсан: О.Баасанхүү, Ж.Эрдэнэбат.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан үг хэлж, Байнгын хорооны дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

Нэг. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол нарын 10 гишүүн 2019.10.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн хамба Д.Чойжамц, мөн хийдийн Тамгын лам С.Даваапүрэв нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, С.Бямбацогт нар үг хэлэв.

С.Бямбацогт: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн 8

Татгалзсан 2

Бүгд 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2019.06.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга З.Мэндсайхан, мөн газрын Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх А.Солонго, Б.Хатантуул, референт Б.Золбоо нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон үг хэлэх гишүүн гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон үг хэлэх гишүүн гараагүй болно.

С.Бямбацогт: “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн 10

Татгалзсан 0

Бүгд 10

100 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлэх гишүүн гараагүй болно.

С.Бямбацогт: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	9
Татгалзсан	1
Бүгд	10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Хаянхярваа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хуулийн төслийг намрын ээлжит чуулганы хугацаанд хэлэлцүүлэгт бэлтгэх цагалбар.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам байлцав.

Төсөлтэй холбогдуулан асуулт тавих гишүүн гараагүй болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны намрын чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төслийг Байнгын хорооны дарга батлахаар тогтов.

Хуралдаан 47 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ Б.БАТГЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

С.Бямбацогт: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амгаланг айлтгая. Байнгын хорооны ирц бүрдсэн тул 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Ганц нэг гишүүн дотроо явж байгаа байх. Тогтохсүрэн, Д.Эрдэнэбат гишүүдийг бас дуудаарай.

.....

Гурав. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.8-д Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгох, шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэж баталж болно гэж заасан байгаа. Үүний дагуу Улсын Их Хурлын Ард нийтийн санал асуулга явуулах тухай 73 дугаар тогтоолыг хүчингүй болгох асуудлыг хэлэлцэнэ.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя.

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Санал хураалтад 10 гишүүн оролцсоноос 100 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хаянхярваа танилцуулъя.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа. Төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хураладаны дэгийн тухай хуулийн 24⁴.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл тогтоож, гурав дахь хэлэлцүүлгийг хийх бэлтгэл ажлыг хангахыг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 68 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг /Ө.Энхтүвшин/, Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/, Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус даалгасугай.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар иргэдэд мэдээлж, тайлбарлан таниулахыг Улсын Их Хурлын нийт гишүүнд даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Ийм тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Мөнхбат гишүүнээр тасаллаа. Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан тогтоол хүчингүй болж байгаа юм байна. Дарааллын хувьд хоёр дахь тогтоол нь төслөөрөө орж ирж байна гэж би ингэж ойлгож байна. Тогтоол хүчингүй болсон нь юу гэсэн үг вэ гэхээр тогтоолын 1 дүгээр заалтад хоёрдугаар хэлэлцүүлгээр батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг баталсан тогтоол байсан. 2 дахь заалт нь Ард нийтийн санал асуулга явуулах тухай заалт байсан.

Одоо энэ тогтоолыг хүчингүй болгоно гэвэл энэ хоёр хоёулаа хүчингүй боллоо гэсэн үг л дээ. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлэг өөрөө хүчингүй болж байгаа юм. Би бол тэгж ойлгож байна. Энэ дээр хуралдаан даргалагчаас би тайлбарыг Тамгын газраас албан ёсоор өгөөч гэж хүсэж байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай журмын тухай хууль болон дэгийн тухай хуульд яг юу гэж үг, өгүүлбэрээр заагдсан байна вэ? Яагаад гэвэл дараа нь энэ тогтоол хийгээд бид нар гуравдугаар хэлэлцүүлэг рүү орох болоход дахин маргаан үүсээд Цэцэд очих магадлал үүсчих вий дээ. Дахиад

хуулийн зөрчил рүү явчих вий дээ. Бид хэлсэн шүү дээ. Анх та нар энэ Үндсэн хуулийг хэлэлцэхдээ хууль зөрчиж эхэлсэн шүү. Хууль зөрчсөнөөсөө болоод асуудал их үүссэн.

Одоо энэ тогтоол хүчингүй болсны дараа ялангуяа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлгийн асуудал хүчингүй болж байна гэсэн үг. Эргэж задрах боломжтой боллоо гэдгийг хүлээн зөвшөөрч байна гэж би ингэж ойлгож байгаа. Энэ биш ээ гэдгийг яг хуулийн заалтын дагуу бид нарт хэлж өгөх зайлшгүй шаардлага байна. Яагаад гэвэл энэ протоколд тусах ёстой. Хэрвээ энэ хуулийн заалтын зөрчил байгаа бол бид нар яаж энэ тогтоолоо авч үзэж дараа нь хоёрдугаар хэлэлцүүлгээ юу гэж үзэх юм бэ гэдгээр хийх ёстой болохоос биш өнөөдөр энийг тодотгоогүйгээр шууд гуравдугаар хэлэлцүүлэгт бэлтгэх тухай энэ тогтоолыг батлах нь зөв үү, буруу юу гэж би ингэж эргэлзээд байгаа юм. Тийм учраас энэ дээр надад нэг тайлбар өгөөч.

С.Бямбацогт: Тамгын газраас тайлбарлая. Энэ гэхдээ, хоёр дахь хэлэлцүүлэг бүрэн яваад дуусчихсан. Хоёр дахь хэлэлцүүлэг дээр дөрөвний гурвын саналаар 57 гишүүнээр бүх зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явагдаад унах нь унаад, дэмжигдэх нь дэмжигдээд явчихсан. Энэ процессын дараа бид нар Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолыг ард нийтийн санал асуулга явуулах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эхийг батлах энэ асуудлыг тусад нь дараагийн процесс болгож хэлэлцсэн. Тэгэхээр үндсэндээ дараагийн процесс буюу 73 дугаар тогтоол дээр хориг тавигдсан. Хоригийг хүлээж авсан. Үүнтэй холбоотойгоор энэ сүүлийн процесс л хүчингүй болж байгаа юм. Түүнээс биш хоёр дахь хэлэлцүүлэг хийгдсэн үйл ажиллагаа бол хүчингүй болоогүй. Яагаад гэвэл тэр тусдаа процесс явагдчихсан учраас.

Энийг зөвлөх хуулийнх нь зүйл, заалтаар нь тайлбарлаад өгчих.

Ж.Бямбадулам: Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр санал хураана гээд. Энэ бол яг хоёрдугаар хэлэлцүүлгийн нэгдсэн хуралдааны хамгийн эцсийн шат байгаа.

Энэ процесс явагдаж дууссаны дараа 14.5-д заасан процесс явагдах уу, өөрөөр хэлбэл, энэ нь энэ хуулийн 14.4-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацаа тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг батлах, эсхүл 17 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал төслийг 14 дүгээр зүйлд зааснаар хэлэлцээд тухайн нэмэлт, өөрчлөлтийг ард нийтийн санал асуулгаар оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар тогтвол ард нийтийн санал асуулга явуулна гээд. Энэ хоёр процессын аль нэг рүү явах ийм салаа дээр очиж байгаа юм. Тэгэхээр одоо ямар процесс дээр ирж байгаа вэ гэвэл зүйл, хэсэг, заалт тус бүрээр нь санал хурааж дууссаны дараа ард нийтийн санал асуулгаар явуулах гэдэг асуудал дээр Ерөнхийлөгч хориг тавиад Улсын Их Хурал уг хоригийг хүлээн авсан учраас 14.5-д заасны дагуу процесс үргэлжлээд явна. 14.4-ийн дараах.

Энэ нь юу вэ гэвэл энэ хуулийн 14.4-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг баталж төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж энэ тухай нийтэд зарлаж мэдээлнэ гээд. Өөрөөр хэлбэл, ард

нийтийн санал асуулгад оруулах нэг дэх хэлэлцүүлэг болон хоёр дахь хэлэлцүүлэг нь өөрөө энэ үе шат нь хүчингүй болж байгаа юм.

С.Бямбацогт: Асуултад Лүндээ гишүүн нэмээд тайлбарлая.

Д.Лүндээжанцан: Би Тамгын газрын ахлах зөвлөхийн уншсан хуулийн заалтыг юу гэж ойлгож байна вэ гэвэл нэгдүгээр хэлэлцүүлэг, хоёрдугаар хэлэлцүүлэг Их Хурал дээр хийгдээд зүйл, хэсэг, заалт болгоноор дөрөвний гурвын дэмжлэг авсан нь үлдээд, ингээд хоцорлоо. Одоо энийгээ яах вэ гэж. Тэгэхээр манайх бол гуравны хоёроос дээших нь ард нийтийн санал асуулгад оруулах нь зүйтэй гээд.

Эхлээд санал асуулгад оруулах нь зүйтэй гэдэг нэг тогтоол гаргачихаад, дараа нь оруулах шийдвэр гаргасны дараа ард нийтийн санал асуулгад оруулах нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг гэж хийгээд, тэгээд хоёрдугаар хэлэлцүүлгийн явцад гарсан нээлттэй үлдээсэн асуудлуудаараа санал хураагаад, найруулгын санал хураагаад уг эхийг баталсан. Тэгвэл санал асуулга явуулах тухай болон уг эхийг баталсан заалттай тогтоол хүчингүй болчихлоо. Ингэхээр эргээд хоёрдугаар хэлэлцүүлгийн төгсгөл дээрээ эргээд хүрээд ирлээ.

Одоо гуравдугаар хэлэлцүүлэг явуулах үүрэг, хугацаа тогтоох тогтоолыг батлах болж байна. Тийм учраас ард нийтийн санал асуулгад оруулахтай холбогдуулсан нэг, хоёрдугаар хэлэлцүүлгийн санал хураалтууд хүчингүй болж дахиж хураагдах болж байна. Харин хоёрдугаар хэлэлцүүлгээр зүйл, хэсэг, заалт бүрээр хураасан санал хэвээрээ үлдэж байна гэж. Энэ бол хоёрдугаар хэлэлцүүлэгт оруулсан асуудал бол хөндөгдөхгүй юм гэж ингэж ойлгогдож байна. Яг хууль зүйнхээ хувьд бол. Тийм учраас хоёрдугаар хэлэлцүүлэг хоёр байгаа байхгүй юу. Ингээд хүмүүс жаахан төөрөгдөөд байх шиг байна.

Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэг, хоёрдугаар хэлэлцүүлгийг хийгээд дууссан. Ард нийтийн санал, асуулгад оруулах асуудлаар уг эхийг батлахтай холбогдуулаад нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг гэж бас тусад нь хийсэн. Тэгэхээр энэ хоёр бол хүчингүй болчихлоо. Харин нэгдсэн чуулганаар хийсэн хоёрдугаар хэлэлцүүлгээ дууслаа. Одоо яах вэ гэдэг асуудал ороод, гуравдугаар хэлэлцүүлэг рүү оруулах асуудлыг шийдэх гэж байна.

Үүнтэй холбогдуулаад гуравдугаар хэлэлцүүлэгт орохдоо хоёрдугаар хэлэлцүүлгээр тогтсон асуудлууд хэвээрээ үлдэнэ. Мөн энэ үеэр нэмэлт, өөрчлөлт оруулах журмын хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу эргэж зарим асуудлуудыг авч үзэх асуудлууд болон ард нийтийн санал асуулгын хоёрдугаар хэлэлцүүлгээр хураасан асуудлаа дахиж хураах шаардлага үүсэж байна гэж ингэж ойлгож байна.

С.Бямбацогт: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

Д.Эрдэнэбат: 73 дугаар тогтоол чинь өөрөө ийм өгүүлбэртэй байсан байхгүй юу.

1.Ард нийтийн санал асуулга явуулах, 2 дахь хэсэг нь болохоор Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай гэж байгаа байхгүй юу. Эхийг батлах тухай гэдэг энэ хэсэг нь адилхан хүчингүй болчихлоо. Эхээ баталсангүй гэсэн ойлголт шууд төрж байна шүү дээ. Тэгэхээр энэ эхээ

батлаагүй л юм чинь энэ хоёрдугаар хэлэлцүүлэг чинь хэвээрээ үлдчихэж байгаа юм биш үү? Эргээд хоёрдугаар хэлэлцүүлэг рүү орох болчихож байгаа юм биш үү?

Энэ бол Цэц дээр очих маргаан л ярьж байна. Дараа нь наадах чинь та нар эхээ батлах хоёрдугаар хэлэлцүүлгийг хүчингүй болгохыг өөрсдөө зөвшөөрчихөөд, эхээ батлах нь буруу юм байна гэдгийг зөвшөөрчихөөд, тэгээд яахаараа гуравдугаар хэлэлцүүлэг рүү ордог юм бэ гэдэг маргаан руу орно шүү дээ. Энийг үгүй гэсэн баталгаатай эрх зүйн заалт нь юу байгаа вэ, тэрийгээ надад хэлээд өгөөч ээ гэж байгаа шүү дээ.

С.Бямбацогт: Тамгын газраас дахиад хариулъя. 73 дугаар тогтоол дээр эх батлах тухай гээд явчихсан. Эх батлах тухай гэдэг маань дараагийн процесс гэж ярьсан шүү дээ. Өмнө нь бид нар зүйл, заалт, хэсэг бүрээрээ 57 гишүүн санал хураачихсан. Тэр бол хүчинтэй байж байгаа. Одоо ганцхан хориг тавигдсантай холбоотой эх батлах тухай тогтоол хүчингүй болж байгаатай холбогдуулаад гуравдугаар хэлэлцүүлэг рүү орох гэж байна. Гуравдугаар хэлэлцүүлэг рүү орохдоо эх гэдэг үг нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эх биш, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл гэдэг үгээр солигдоод л, ийм процессоор л явах гэж байгаа байх. Энийг хуулийнх нь заалтын хувьд тайлбарлаад өг дөө. Ажлын хэсгийн микрофон.

Ж.Бямбадулам: Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт хоёр дахь хэлэлцүүлгээр зүйл, хэсэг, заалт бүрээр санал хурааж шийдвэрлэсэн төслийг ард нийтийн санал асуулгад оруулах эх болгон баталж, уг эхээр ард нийтийн санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын тогтоол гаргана гэж байгаа. Энэ 17 дугаар зүйл нь өөрөө ард нийтийн санал асуулгад оруулах процессыг нь зааж өгсөн зүйл байгаа юм. Тэгэхээр энэ хоёрдугаар хэлэлцүүлэг гэдэг нь ард нийтийн санал асуулгад оруулах тэр нэг, хоёр дахь хэлэлцүүлгийн хоёр дахь хэлэлцүүлгийн эцэст нь баталж байгаа тэр процессыг ярьж байгаа бөгөөд журмын хуулийн 14 дүгээр зүйлд заасан хоёрдугаар хэлэлцүүлэг гэдгээс өөр процессыг яриад байгаа юм. Түрүүн Лүндээжанцан гишүүний ярьсан шиг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж байгаа нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг, дараагийн 17 дугаар зүйлд заасан нь болохоор ард нийтийн санал асуулгад оруулах төслийг.

С.Бямбацогт: Мөнхбат гишүүн асуултаа татлаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалт явуулъя. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт

Санал хураалтад 10 гишүүн оролцсоноос 9 гишүүн дэмжсэн байна. Санал хураалт дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх тухай үүрэг, хугацаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Хаянхярваа гишүүн танилцуулъя.

Дараагийн асуудалд оръё.

.....

Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:

ПРОТОКОЛЫН АЛБАНЫ

ШИНЖЭЭЧ Б.БАТГЭРЭЛ